



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.02 № 04/686
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА С.АДЬЯА ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Монгол Ардын намын хорооны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (41 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Монгол Ардын намын хороонд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт 41 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



МОНГОЛ АРДЫН НАМ

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН
ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН
ХӨТӨЛБӨР

2024 ОН



АГУУЛГА:

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. ОРЛОГОТой ИРГЭН
- 1.2. ЭРҮҮЛ, БОЛОВСРОЛТОЙ ИРГЭН
- 1.3. ТОГТВОРТОЙ ГЭР БҮЛ
- 1.4. ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ
- 1.5. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ
- 1.6. ХБИ /ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ/-ИЙН ХӨГЖИЛ
- 1.7. АХМАДЫН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ
- 1.8. ӨВ СОЁЛ, СПОРТЫН ХӨГЖИЛ

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1. ХАА-Н ҮЙЛДВЭРЛЭЛ
- 2.2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЖИЛТ
- 2.3. ТӨСӨВ САНХҮҮ, СТАТИСТИК
- 2.4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 3.1. БАЙГАЛЬ ОРЧИН
- 3.2. ХОГ ХАЯГДАЛ
- 3.3. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ, СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТЫН БОДЛОГО

- 4.1. ДЭД БҮТЭЦ
- 4.2. СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТ

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 5.1. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Сумын МАН-ын хорооны Тэргүүлэгчдийн
2024 онысарын ...өдрийнр
тогтоолоор батлав.

ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН МАН-ААС
ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ МУ-ын алсын хараа – 2050 хөгжлийн хөтөлбөр
- ✓ Хөгжсөн Хөвсгөл 2030 хөтөлбөр
- ✓ Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- ✓ 2024 оны УИХ болон аймгийн ИТХ-ын сонгуульд МАН-аас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр.
- ✓ Сумын ард иргэдийн санал

УРИА: “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА”

ЗОРИЛГО: ОРОН НУТГИЙНХАА ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ИРГЭН БҮРИЙН ОРОЛЦООГ ХАНГАЖ, ЦЭВЭР ЦЭМЦГЭР “НОГООН” ЭРДЭНЭБУЛГАНД ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭЖ, ӨРХ БҮР ҮЙЛДВЭРЛЭГЧ БАЙХАД БИДНИЙ ЗОРИЛГО ОРШИНО.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. ОРЛОГОТОЙ ИРГЭН

- 1.1.1. “Өрх бүр үйлдвэрлэгч” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, өрхийн бичил бизнесийг шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй бага хүүтэй зээл, хөтөлбөрт хамруулах замаар дэмжинэ.
- 1.1.2. Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг гадаадын болон дотоодын мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.1.3. Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.1.4. **Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн** үзэсгэлэн худалдааг жилд 2 удаа зохион байгуулж, сумын брендийг нэр төрлийг нэмэгдүүлж, баялаг бүтээгчдээ дэмжинэ.
- 1.1.5. Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны мах, хүнсний ногооны тендерийг орон нутагтаа зарлаж, бэлтгэн нийлүүлэлтийг дэмжиж ажиллана.

[Handwritten signature]

1.2. ЭРҮҮЛ, БОЛОВСРОЛТОЙ ИРГЭН

- 1.2.1. Эх, хүүхдийн эндэгдэлгүй ажиллаж, “Хүүхдэд ээлтэй сум болох” зорилтыг үргэлжлүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 1.2.2. Иргэн бүр /ялангуяа эмэгтэйчүүд/ эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд ЭМ-ийн болон ТББ-уудтай хамтран ажиллана.
- 1.2.3. “Эмийн зохистой хэрэглээ” аяныг жил бүр зохион байгуулж, нэн зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлж, эмийн чанар, аюулгүй байдалд тавих, иргэд олон нийт төрийн хяналтыг сайжруулна.
- 1.2.4. Сумын эрүүл мэндийн төвийн 2 дугаар байрыг засварлаж, иргэдэд чиглэсэн сэргээн засах төв, чийрэгжүүлэлтийн төв, сургалтын танхим, мэргэжилтэнгүүдийн ажлын өрөө зэрэг зориулалтаар ашиглах боломжоор хангана.
- 1.2.5. Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд хамруулж, “Чадварлаг багш” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.2.6. Мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлж, залуу багш нарын хөгжлийг дэмжих, ахмад багш нарын зөвлөх үйлчилгээг нэвтрүүлж ажиллана.
- 1.2.7. СӨБ-ын байгууллагын боловсон хүчин, багшийн хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.2.8. Суралцагчид болон иргэдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, мэргэжил сонголт, эрүүл амьдрахад туслах чиг үүрэгтэй мэргэжлийн сэтгэл зүйчийг ЕБС болон ЭМТ-д ажиллуулна.
- 1.2.9. ЕБС, СӨББ, ЭМТ-үүдэд хүүхдийн сувилал, хөдөлмөр зуслан, зуны сургалт зохион байгуулах боломжийг дэмжинэ.
- 1.2.10. “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” “ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ ШҮД” “УМАЙН ХҮЗҮҮН ХАВДАРГҮЙ МОНГОЛ” хөтөлбөрүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 1.3. ТОГТВОРТОЙ ГЭР БҮЛ
- 1.3.1. Жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд онцгой анхаарч, ургийн эрт үеийн оношилгоонд, жирэмсний хяналтад бүрэн авч, сургалт арга зүйгээр хангана.
- 1.3.2. Эмэгтэйчүүдийн үүсгэл санаачилгын клуб, холбоо, нөхөрлөл ТББ-ыг бодлогоор дэмжин хамтран ажиллана.
- 1.3.3. Ганц бие, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэхэд дэмжинэ.
- 1.3.4. Төрийн худалдан авалтанд сумынхаа баялаг бүтээгч, үйлдвэрлэгчдээ давуу эрх олгох, зарчим баримтална.
- 1.3.5. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг үндэслэн, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- 1.3.6. Хүн бүр угийн бичгээ хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, удмын сангаа хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлнэ.



- 1.3.7. Их, дээд сургууль, МСҮТ төгссөн залуучуудаа сумандаа эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэж, цахим мэдээллийн систем, хөдөлмөрийн мэдээллийн санг бий болгоно.
- 1.3.8. “Өрх бүр үйлдвэрлэгч” хөтөлбөрийн хүрээнд дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлнэ.
- 1.3.9. Залуу гэр бүлийн чуулга уулзалт, сургалт арга хэмжээг жилд 2 удаа зохион байгуулж хэвшүүлнэ.
- 1.3.10. “Ёслол хүндэтгэлийн өргөө”-нд орон нутгийн залуусын хуримын үйл ажиллагааг зохион байгуулдаг уламжлал бий болгоно.

1.4. ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

- 1.4.1. Төрийн болон хувийн байгууллагуудын “Хүүхэд хамгааллын баг”, дотоод аудитор, ХАБ-ын ажлыг эрчимжүүлж, хүүхдэд ээлтэй байдлыг үнэлж дүгнэх, урамшуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.2. “Хүүхдийн амьдрах, сурах, хамгаалагдах, хөгжлийг дэмжих чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрүүдийг нэвтрүүлж, хүүхдийн төлөө зарцуулах санхүүжилтийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ.
- 1.4.3. Хүүхдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинд тогтмол хамруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.4.4. Хөдөлмөр зуслан болон хүүхдийн зуслан, өдөр өнжүүлэх бүлэг, зуны сургалтын танхим байгуулах хувийн хэвшлийн үүсгэл санаачлагыг дэмжинэ

1.5. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ

- 1.5.1. Эрэлттэй ажлын байрны судалгаа гаргаж, аймгийн Политехникийн коллежтэй хамтран мэргэжилтэй ажилтан бэлтгэх, залуусыг ажлын байраар хангаж ажиллана.
- 1.5.2. “**Орон сууц**” хөтөлбөр хэрэгжүүлж, залуу гэр бүлд таатай нөхцлөөр орон сууцтай болох боломжийг бий болгоно.
- 1.5.3. Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.5.4. Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “Залуу гэр бүл” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ

1.6. ХБИ /ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ/-ИЙН ХӨГЖИЛ

- 1.6.1. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүрэн хамруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- 1.6.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зорилтот бүлгийн өрхийг нэн тэргүүнд хамруулж, өрхийн орлогыг нь нэмэгдүүлнэ.

1.6.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэх, хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.6.4. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд хэрэгцээт үйлчилгээгээ авах нөхцлийг төрийн болон бусад бүх байгууллагад бүрдүүлнэ.

1.6.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тоног төхөөрөмж, эмчилгээний аппарат хэрэгсэл бүхий танхимыг ЭМТ-ийг түшиглэн бий болгоно.

1.7. АХМАДЫН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

1.7.1. Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.

1.7.2. Ахмад настанд чиглэсэн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.

1.7.3. Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд баялагийн сан, нийгмийн даатгалын сангаар болон ипотека, 3%-ийн зээлээр дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлээр иргэдээ орон сууцжуулах төрийн бодлогыг сумандаа хэрэгжүүлнэ.

1.8. ӨВ СОЁЛ, СПОРТЫН ХӨГЖИЛ

1.8.1. Соёлын төвийн техник хэрэгсэл, материаллаг баазыг бэхжүүлж, иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмж, давтамжийг нэмэгдүүлнэ.

1.8.2. Орон нутагт тэргүүлэх чиглэлийн болон үндэсний спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлж, нийтийг хамарсан спортын арга хэмжээг өргөжүүлнэ.

1.8.3. Үндэсний хөгжмийн зэмсгээр бүрэн хангаж, соёлын төвийн дэргэд “Үндэсний хөгжмийн сургалт”-ыг үр дүнтэй хичээллүүлнэ.

1.8.4. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, Монгол бичгийн олимпиадыг иргэдийн дунд уламжлал болгон явуулна.

1.8.5. Түүх, соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.

1.8.6. Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

2.1.1. ХАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэх бодлого баримталж, уг салбарт фермерийн аж ахуй болон хоршооллыг бодлогоор дэмжинэ.

2.1.2. “Монгол мал” хөтөлбөр болон “Шинэ хөдөө” төслийн хүрээнд мал сүргээ эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх бодлого баримталж, хувийн мал эмнэлэгүүдийг бэхжүүлнэ.

0000000006

2.1.3. Хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд сумандаа “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг өрнүүлж, малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

2.1.4. МАА-ын бүтээгдэхүүний /мах, сүү, арьс шир, ноос, ноолуур/ боловсруулалт хийх жижиг, дунд үйлдвэр цехийг бодлогоор дэмжин, зээл төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авна.

2.1.5. Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, “Атар-IV” аяныг орон нутагтаа үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.1.6. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, бодлогын хүрээнд “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийг орон нутагтаа үргэлжлүүлэн, гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

2.1.7. Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуй болон гахай, тахиа, өндөг, зөгийн аж ахуй эрхлэх үүсгэл санаачлагыг бодлогоор дэмжин хөгжүүлнэ.

2.1.8. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд малын тэжээлийн үйлдвэрийг байгуулах бодлогыг баримталж, орон нутгийн өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

2.1.9. Малчид, тариаланчид, ногоочдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлж, малын эмч, мал зүйч бэлтгэх бодлого баримтлана.


2.1.10. Төмс, хүнсний ногоо тариалагчдын эцсийн бүтээгдэхүүнийг орон нутгийн төсвийн худалдан авалтаар борлуулахад дэмжлэг үзүүлнэ.

2.2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

2.2.1. Сумын эдийн засагт нөлөө үзүүлэхүйц, орон нутгийн түүхий эдэд түшиглэсэн томоохон болон жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлж, ДНБ үйлдвэрлэлтийг 2023 оныхоос 2 дахин нэмэгдүүлнэ.

2.2.2. Ажлын байрыг олноор бий болгох, тогтвортой үйл ажиллагаа явуулах дараах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин хөгжүүлнэ. Үүнд:

- Ахуйн үйлчилгээний газар-үндэсний хувцас үйлдвэрлэл
- Ахуйн үйлчилгээний газар- гар утас засвар, гутал засвар, угаалгын машин бусад цахилгаан хэрэгслийн засвар
- Мод боловсруулах, мод, модон эдлэлийн үйлдвэр
- Шахмал түлшний цех
- МАА-н бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт хийх өрхийн үйлдвэр
- Монгол гэр, тавилгын өрхийн үйлдвэр
- Жимс жимсгэнэ болон хүнсний ногоо нөөцлөх, даршлах өрхийн үйлдвэр
- Талх гурилан бүтээгдэхүүний өрхийн үйлдвэр
- Гар урлал эрхлэгчийн өрхийн үйлдвэр



[Handwritten signature]

0000000007

2.2.3. Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэхийг иргэддээ уриалж, төрийн худалдан авалтад орон нутгийн үйлдвэр, бизнес эрхлэгчид, баялаг бүтээгчид оролцохийг дэмжинэ.

2.2.4. Эрдэнэбулган сумын 2025-2028 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулж, уг хөтөлбөрийг энэ 4 жилд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.3. ТӨСӨВ САНХҮҮ, СТАТИСТИК

2.3.1. Орон нутгийн татварын бааз суурийг өргөтгөн, төсвийн орлогыг нэмэгдүүлж, орон нутаг бие даан хөгжих бодлогыг баримтлана.

2.3.2. Төсөв санхүүгийн шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, санхүүгийн албаны ажилтнуудыг чадавхижуулна.

2.3.3. Төр хувийн хэвшлийн статистик, хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт тооцооллыг сайжруулж, цахим үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

2.4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.4.1. Аялал жуулчлалыг сумын эдийн засгийн туслах салбарын нэг болгон хөгжүүлэх хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.

2.4.2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сумандаа бий болгох, түүх, соёлын болон орон нутагтай танилцах аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлнэ.

2.4.3. Дотоодын амрагч, аялагчдад зориулсан амралт, зугаалгын бүсчлэлийг тогтоож, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, гар үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

2.4.4. Байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдийг түшиглэсэн тогтвортой эко аялал жуулчлалыг сумандаа хөгжүүлнэ.

2.4.5. Аялал жуулчлалын бүс нутагт харъяалалтай айл өрхийг гэр буудал ажиллуулах дэмжлэг, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.4.6. Аялал жуулчлалаар зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний газрыг байгуулна.

2.4.7. Өвлийн аялал жуулчлал, арга хэмжээний тоог нэмэгдүүлж, цахим санг бүрдүүлнэ.

ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. БАЙГАЛЬ ОРЧИН

3.1.1. Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээхэд нутгийн иргэд, олон нийтэд түшиглэсэн менежментийг хэрэгжүүлнэ.

3.1.2. "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлж, айл өрх бүр эзэмшлийн газартаа мод тарих аяныг өрнүүлж, бодлогоор дэмжинэ.



3.1.3. Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.

3.1.4. Ус, хөрс, орчны бохирдлыг багасгах, түүнтэй хийх тэмцэлд төр, олон нийт, иргэдийн оролцоо, хяналтыг өндөржүүлж, ногоон байгууламжтай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.1.5. Ган, зуд, гал түймэр, үер, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшгаас сэргийлэх, болзошгүй эрсдэлийг бууруулах, ажлын шинэ менежментийг хэрэгжүүлнэ.

3.1.6. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн, малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэн, бэлчээр ашиглалтын журам гарган, малчдыг хариуцлагажуулна.

3.1.7. Голуудын хамгаалалтын зурвасыг шинэчлэн тогтоож, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх отог байгууламжийг Өтөгт, Эгийн зах, Бүргийн хад орчимд хувийн хэвшлийн оролцоотойгоор бий болгохыг дэмжинэ.

3.1.8. Цаг уурын өртөөг бэхжүүлж, цаг агаарын мэдээ, мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэх, түгээх ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

3.1.9. Түймэрт өртсөн, хортонд идэгдсэн, тахилга шүтээнт уул толгодын орчинг ойжуулах арга хэмжээг иргэд, ойн нөхөрлөлүүд, төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

3.2. ХОГ ХАЯГДАЛ

3.2.1. Хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах, байгальд халгүй аргаар устгах технологи, менежментийг судлан хэрэгжүүлж эхэлнэ.

3.2.2. Хогийн цэгийг эзэнжүүлэх, дайвар худалдан авч, дахин боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллах

3.2.3. ЭМТ-ын аюултай хог хаягдлын цэгийг стандартын түвшинд шинэчлэн засварлана.

3.3. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

3.3.1. Охид бүсгүйчүүдэд “Ногоон боловсрол” олгох сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.3.2. Эмэгтэйчүүдийн гар урлалын “БҮСГҮЙ” урланг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, үйлдвэрлэлийг дэмжих, орлогоороо санжүүжих боломжоор хангахад иргэд олон нийт, төсөл хөтөлбөрийн дэмжлэгт тулгуурлан хамтран ажиллана.

3.3.3. Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих хүрээнд цэвэрлэгээний болон дотоод засал, засварын баг байгуулах санал санаачлагыг дэмжиж, 35-50 түр ажлын байрыг бий болгоно.

3.3.4. Нэг эмэгтэй нэг ба түүнээс дээш цэцэг тарьж, борлуулах “Бүсгүй цэцэг” арга хэмжээг жил бүрийн “Дальны баяр”-аар зохион байгуулж, эмэгтэйчүүдийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ба айл өрх, гудамж талбай, албан байгууллагуудыг цэцэгжүүлнэ.

ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ, СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТЫН БОДЛОГО

4.1. ДЭД БҮТЭЦ


- 4.1.1. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дагуу шинээр буй болж байгаа суурьшлийн бүсийн айл өрх, үйлчилгээний газруудыг цахилгаанаар хангах арга хэмжээ авна.
- 4.1.2. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх ажлыг хуулийн хүрээнд төлөвлөлтийн дагуу олгох, гэр бүлийн хэрэгцээний газар өмчлөлийг нэмэгдүүлнэ.
- 4.1.3. Сумын төвийн дулааны шугамын ашиглалтын горим, аюулгүй байдалд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг яаралтай авч ажиллана.
- 4.1.4 Сумын төвийн доторхи цахилгааны О4-ын шугамыг төмөр бетонон тулгууртай сип шугамаар солих, трансформаторуудыг шинэчилэх асуудлыг мэргэжлийн газруудаар шийдвэрлэх арга хэмжээ авна.
- 4.1.5. Сумын төв доторхи гудамж бүхий замуудыг засч сайжруулан, явган хүний зам тавих, тэмдэгжүүлэх үүсгэл санаачлагыг дэмжин ажиллана.
- 4.1.6 2 ба 3 дугаар багуудад Юнителийн үүрэн операторын сүлжээ оруулах
- 4.1.7. 2 дугаар багийн зуслангийн төв орчмыг эрчим хүчтэй холбох
- 4.1.8. Чичингийн замыг засварлах /овоон жалгаас дөрөлж хүртэлх зам-5 км, уртын амны гүүрнээс гулзгайн ам хүртэл-5 км/
- 4.1.9 Давааны нарийний замыг засах, сайжруулах
- 4.1.10 Сумын хилийн цэс, нутгийн зарим маргаантай заагуудын зэргэлдээх аймаг сумдын удирдлагуудтай тохиролцож, засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.

4.2. СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТ

- 4.2.1. Сумын төвийн гудамжуудыг эмх цэгцтэй болгож, дугаарлах, хаягжуулах ажлыг эхлүүлж, "Жишиг гудамж" төсөл хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Айл өрхүүдэд био жорлон, бохирын байгууламж байгуулах замаар нүхэн жорлонгоос татгалзах хөдөлгөөн өрнүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.
- 4.2.3. Золбин нохой, муур устгалт, хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн ажлыг тогтмолжуулж, хууль журмуудын хэрэгжилтийг ханган ажиллана.
- 4.2.4. Өвлийн улиралд сумын төвд болон багууд руу таксины үйлчилгээ эрхлэх үүсгэл санаачлагыг дэмжинэ.
- 4.2.7. Сумын төвөөс малтай иргэдийг гаргах, малчны хороолол бий болгон суурьшуулах асуудлаар иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж шийдвэрлэнэ.
- 4.2.8. "Эрдэнэбулган- БРЭНД" бүтээгдэхүүний борлуулалтын цэгийг байгуулна.

ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 5.1. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ /Төрийн албыг хүний эрхийг дээдэлсэн, ил тод нээлттэй, мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй, хариуцлагатай алба болгон төлөвшүүлнэ/



- 5.1.1. Төрийн албаны аливаа шийдвэрт хүний эрхийг хангаж байгаа байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний биелэлтэнд судалгаа хийж, Монгол Улсын Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж ажиллана.
- 5.1.2. Нутгийн захиргааны байгууллагын тогтоол, шийдвэр, гэрээ хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 5.1.3. Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, "E-mongolia" системийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.1.4. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, үр дүнг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлнэ.
- 5.1.5. Нийгмийн дэг журам хангах, гэмт хэрэг зөөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, талаар 2025-2028 оны төлөвлөгөө гарган, түүнийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 5.1.6. Төрийн албан хаагчдын хариуцлага, ажлын бүтээмж, цаг ашиглалтыг сайжруулж, нийтийн сонсголын цагийг тогтмолжуулна.
- 5.1.7. Төр, хувийн хэвшлийн түншлэл болон ТББ-ын үйл ажиллагааг төрөөс дэмжиж төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх зарчим баримтална.
- 5.1.8. Гамшигт үзэгдлүүд (ган зуд, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 5.1.9. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 5.1.10. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.
- 5.1.11. Төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг орон нутаг, төрийн албаны анхан шатны нэгжид ажиллуулан дадлагажуулах замаар мэдлэг чадвар, туршлагыг нэмэгдүүлнэ.
- 5.1.12. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, орон нутгийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.
- 5.1.13. Хүн амын хүнсний болон эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах зорилгоор гарч буй зөрчил дутагдлыг арилгах, хяналт тавих үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 5.1.14. Нийгмийн дэг журам хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар 2025-2028 оны төлөвлөгөө гарган түүнийг үе шаттай хэрэгжүүлнэ. Орон нутагт ажиллах багш, эмч, төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн тогтвор суурьшилтай ажиллуулна.
- 5.1.15. Орон нутагт ажиллах багш, эмч, төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн тогтвор суурьшилтай ажиллуулна.

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



0000000011